



Жилийн Тайлан

2025 он

WWW.GRANDLOTTO.MN



КОМПАНИЙН УДИРДЛАГА	3
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА	4
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК, ТАЙЛАН	5
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН	5
КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ	6
АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	9

КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

Хүснэгт 1. “Гранд Системс” ХК-ийн товч танилцуулга

Компанийн нэр	Гранд Системс ХК
Хуулийн этгээдийн улсын бүртгэл	УБД: 9011779001 РД: 6371477
Үйл ажиллагааны чиглэл	• Программ хангамжийн үйлчилгээ • Мэдээлэл технологийн үйл ажиллагаа • Эд мөнгөний хонжворт сугалаа гаргах
Санхүүгийн үзүүлэлт /2026.12.31/	Хөрөнгө: 1.6 тэрбум төгрөг Өмч: 0.6 тэрбум төгрөг Өр төлбөр: 1.0 тэрбум төгрөг
Гүйцэтгэх захирал	Д.Энхбилэг
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар, 1 хороо, 13, Нарны зам 62, 503 тоот Утас: 976-94545057 И-мэйл: info@grandlotto.mn

Гранд Системс ХК нь 2018 онд үүсгэн байгуулагдсан ба програм хангамжийн үйлчилгээ, мэдээллийн технологи, эд мөнгөний хонжворт сугалаа гаргах үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг.

Компани нь үүсгэн байгуулагдсан цагаас хойш үндэсний томоохон үйлдвэрлэгч аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллаж, тэдгээрийн сугалаа гаргах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллаж ирсэн. Харин 2025 оноос өөрийн нэрээр Гранд сугалааг гаргаж, азтан тодруулж ажиллаж байна.

КОМПАНИЙН УДИРДЛАГА

Гранд Системс нь 2024 онд Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлж, олон нийтэд хувьцаагаа амжилттай санал болгосноор анхны сугалааны хувьцаат компани болсон. Ингэснээр компани нь нээлттэй ил тод компанийн засаглалтай болсон бөгөөд компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал юм. Компани нь хувьцаат компани болсноос хойш жил бүрийн санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа хийж, уг хурлын бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргаж ирсэн.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Компанийн төлөөлөн удирдах зөвлөл нь компанийг удирдлагаар хангаж, стратеги болон хэтийн төлөвийг тодорхойлох, хувьцаа эзэмшигчдийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажиллаж байна. Компанийн төлөөлөн

удирдах зөвлөл нь нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд үүнээс 3 гишүүн нь хараат бусаар ажиллаж байна.

Хүснэгт 2. “Гранд Системс” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

№	Удирдлагын нэр	Албан тушаал	Мэргэжил
1.	О.Болд	ТУЗ-ийн дарга	Бизнес удирдлага
2.	Н.Цэлмэгсайхан	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Нягтлан бодогч
3.	Б.Баярмаа	ТУЗ-ийн ердийн гишүүн	Хүн ам зүйч
4.	Э.Тэнүүн	ТУЗ-ийн ердийн гишүүн	График дизайнер, бизнес удирдлага
5.	Н.Лхамсүрэн	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Эдийн засагч
6.	А.Батболд	ТУЗ-ийн хараат бус гишүүн	Эрх зүйч
7.	О.Халтар	ТУЗ-ийн ердийн гишүүн	Механикч
8.	Д.Энхбилэг	ТУЗ-ийн ердийн гишүүн	Эдийн засгийн мэдээлэл зүйч, Санхүүгийн менежмент
9.	Р.Тогтохбаатар	ТУЗ-ийн ердийн гишүүн	Эрх зүйч

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

Сугалаат худалдааны хөтөлбөр

Компани нь 2020 оноос үндэсний томоохон аж ахуйн нэгжүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээний борлуулалтыг дэмжих зорилготой сугалаат худалдааны хөтөлбөрийг хамтран ажиллах гэрээний үндсэн дээр зохион байгуулж ажилласан. Энэхүү хамтран ажиллах гэрээний дагуу компани нь сугалаат хөтөлбөр явуулж буй аж ахуйн нэгжүүдийн сугалаа явуулахад шаардлагатай програм хангамж, тоног төхөөрөмжөөр хангаж ажилласан болно. Харин компани нь өөрийн нэр дээр ямар нэгэн сугалааг гаргаж ажиллаагүй болно.

Гранд сугалаа

2025 онд Гранд Системс нь Гранд сугалааг явуулж эхэлсэн бөгөөд уг сугалаа нь цор ганц супер ялагчтай мөн 2 болон 3 дугаар байрын хонжвортой сугалаа юм. Компани нь цаашид Гранд лотто, Гранд Стикер, Гранд скрач зэрэг сугалааны төрлүүдийг нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

Сугалааны тохирол

Гранд сугалааны тохирлын хувьд худалдаанд гаргасан тасалбар 100% борлуулагдаж дууссаны дараа эсхүл хуваарийн дагуу сар бүр явагддаг. Тохирлыг тухайн зарлагдсан хонжворын тасалбарын борлуулалт дүүрсэн үед компани өөрийн студийс Тохирлын машиныг ашиглан Facebook хуудсаар шууд дамжуулан хүргэдэг.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТАТИСТИК, ТАЙЛАН

Гранд сугалаа

2025 оны байдлаар компани нь нийт 106 сугалааны тохирлыг зохион байгуулж, 111 мянган хүн оролцсон байна. Үүнээс 207 азтан тодруулж, 800 сая төгрөгийн хонжворыг олгосон байна.

Хүснэгт 4. “Гранд Системс” ХК-ийн сугалааны тасалбарын борлуулалт

Тохирол		2025
Борлуулалтын орлого	сая төгрөг	1,210
Азтан		207
Харилцагч	мянган хүн	111
Шагнал	сая төгрөг	800

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Компанийн ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүн нь 2024 оны 12 сарын 31-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгогдсон ба Компани Хувьцаат компани болгон хэлбэрээ өөрчилснөөс хойших анхны ТУЗ-ийн бүрэлдэхүүн юм.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2025 онд нийт 7 удаа хуралдсан ба дараах асуудлыг шийдвэрлэсэн:

1. ТУЗ-ийн дарга сонгох тухай
2. ТУЗ-ийн дэргэдэх хороодын гишүүд сонгох тухай
3. ТУЗ-ийн сургалтын төлөвлөгөө батлах тухай
4. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай
5. Компанийн дотоод журамд өөрчлөлт оруулах тухай
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай
7. Данс захиран зарцуулах эрх олгох тухай
8. Үнэт цаасны данс нээх, эрх олгох тухай
9. Хувьцааг эргүүлэн худалдан авч, халааслах тухай

ТУЗ-ийн дэргэдэх хороодын тайлан

Аудитын хороо:

Компанийн аудитын хороо нь 2025 оны 1 дүгээр улиралд Компанийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн аудитын дүгнэлтийн талаар санал зөвлөмжөө ТУЗ-д хүргүүлж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлж ажилласан.

Цалин урамшууллын хороо:

Компанийн цалин урамшууллын хороо нь тайлант хугацаанд компанийн хүний нөөцийн бодлого, журам, байгууллагын орон, тоо бүтэц баталсан шийдвэр, хөдөлмөрийн болон цалин урамшууллын холбогдох журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан. Тайлант хугацаанд тус хорооноос тухайлсан зөвлөмж, дүгнэлт гаргаагүй болно.

Нэр дэвшүүлэх хороо:

Компанийн ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвшүүлэх хороо нь Компанийн цалин урамшууллын бодлогод тусгагдсан асуудлаар Гүйцэтгэх удирдлагаас ТУЗ-ийн хуралд танилцуулсан тайлан, мэдээлэлд тогтмол хяналт тавьж ажиллаж байна.

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

1. Гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал

Компани нь Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааг дараах жишиг үзүүлэлтээр тооцон урамшуулалт цалинг тооцдог.

1. KPI-ийн бүтэц

Гүйцэтгэх удирдлагын гүйцэтгэлийг дараах үндсэн 4 бүлэг үзүүлэлтээр үнэлнэ:

	Үзүүлэлт	Жин
1	Санхүүгийн гүйцэтгэл	40%
2	Үйл ажиллагаа	30%
3	Эрсдэл ба комплаенс	15%
4	Хувь хүний гүйцэтгэл	15%
5	Нийт	100%

2. KPI үзүүлэлтүүд

2.1 Санхүүгийн гүйцэтгэл (40%)

KPI	Зорилт	Жин
Орлогын өсөлт	$\geq 15\%$	15%
Цэвэр ашиг	$\geq$ төлөвлөгөө	15%
Зардлын харьцаа	$\leq$ төлөвлөгөө	10%

2.2 Үйл ажиллагааны гүйцэтгэл (30%)

KPI	Зорилт	Жин
Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт	$\geq 90\%$	15%
Төслийн гүйцэтгэл	хугацаандаа $\geq 90\%$	10%
Процесс сайжруулалт	≥ 2 санаачилга	5%

2.3 Эрсдэл ба комплаенс (15%)

KPI	Зорилт	Жин
Зөрчил, торгууль	0 тохиолдол	10%
Дотоод хяналтын үнэлгээ	$\geq 85\%$	5%

2.4 Хувь хүний гүйцэтгэл (15%)

KPI	Зорилт	Жин
KPI биелэлт	≥ 90%	10%
Багийн удирдлага	≥ 85% үнэлгээ	5%

3. Үнэлгээний аргачлал

- KPI бүрийг 0–100%-иар үнэлнэ.

2. Компанийн дотоод аудитын тогтолцоо, үйл ажиллагаа

Компанийн дотоод аудитын тогтолцоо нь компанийн үйл ажиллагааны үр ашиг, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцооны үр нөлөөг хангах зорилгоор хэрэгжүүлдэг.

1. Бүтэц, зохион байгуулалт

Компанид дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Аудитын хороотой.

2. Чиг үүрэг

Дотоод аудитын нэгж нь дараах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Компанийн дотоод хяналтын тогтолцооны үр нөлөөг үнэлэх
- Эрсдэлийн удирдлагын хэрэгжилтэд хяналт тавих
- Санхүү, үйл ажиллагаа, комплаенсын аудит хийх
- Зөрчил, дутагдлыг илрүүлж, зөвлөмж боловсруулах
- Илэрсэн асуудлын хэрэгжилтэд хяналт тавих

3. Тайлант хугацаанд хийж хэрэгжүүлсэн ажил

Тайлант хугацаанд дотоод аудитын ажилтан нь батлагдсан төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Санхүүгийн болон үйл ажиллагааны дотоод хяналтыг тогтмол гүйцэтгэсэн
- Дотоод хяналтын орчны үнэлгээг тогтмол хийсэн
- Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах зөвлөмж хүргүүлсэн
- Зөвлөмжийн хэрэгжилтийн явцад хяналт тавьж ажилласан

4. Үр дүн

Дотоод аудитын үйл ажиллагааны үр дүнд компанийн дотоод хяналтын тогтолцоо сайжирч, эрсдэлийг бууруулах, үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэхэд тодорхой ахиц гарсан болно.

3. Байгаль орчин, нийгэм, засаглал (ESG)

Компанийн үйл ажиллагаа нь байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) зарчмуудыг баримтлахын зэрэгцээ стратегийн зорилтуудад хүрэхэд хүчин чармайлт гарган ажиллаж байна.

1. Байгаль орчны хүчин зүйл (Environmental)

Компанийн хувьд сугалааны үйл ажиллагааг бүрэн цахим хэлбэрээр явуулдаг бөгөөд цаасан тасалбар ашигладаггүй. Энэ нь байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, нөөцийн зохистой хэрэглээг дэмжихэд хувь нэмэр оруулж байна.

2. Нийгмийн хүчин зүйл (Social)

Компанийн үйл ажиллагаа нь олон нийтэд ил тод, нээлттэй байх зарчимд тулгуурладаг. Тайлант хугацаанд сугалааны тохирол, үр дүнг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлж, хэрэглэгчдэд ойлгомжтой, хүртээмжтэй мэдээллийг тогтмол хүргэн ажилласан.

Мөн компанийн дотоод журамд нийгмийн хариуцлагын хүрээнд орлогын тодорхой хэсгийг сайн үйлсэд зарцуулах боломжийг тусгасан бөгөөд компанийн үйл ажиллагаа тогтворжиж эхэлсэнтэй уялдуулан уг зохицуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх, нийгэмд чиглэсэн сайн дурын болон хандивын үйл ажиллагааг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

3. Засаглал (Governance)

Компанийн засаглал нь ил тод байдал, хяналт, хариуцлагад тулгуурладаг. Тайлант хугацаанд сугалааны үйл ажиллагааг холбогдох дүрэм, журмын дагуу зохион байгуулж, дотоод хяналт, аудитын тогтолцоог сайжруулан, мэдээллийн үнэн зөв, шуурхай байдлыг ханган ажилласан.

4. Стратегийн зорилтын хэрэгжилт ба үр дүн

Компанийн стратегийн зорилт нь үйл ажиллагааны үр ашиг, системийн найдвартай байдал, хэрэглэгчийн итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Тайлант хугацаанд сугалааны системийн үр нөлөө, гүйцэтгэлийг сайжруулж, үйл ажиллагааны тасралтгүй, найдвартай байдлыг ханган, хэрэглэгчийн итгэл, оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үр дүнд хүрсэн.

5. Мэдээллийн ил тод байдал (Цахим хуудас)

Компанийн үйл ажиллагаа, сугалааны тохирол болон үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаар дамжуулан олон нийтэд ил тод, тогтмол хүргэж байна.

4. Оролцогч талуудтай хамтран ажилласан талаарх мэдээлэл

Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудтай үр дүнтэй, ил тод хамтран ажиллах нь стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой бөгөөд тайлант хугацаанд дараах чиглэлд анхаарч ажилласан болно.

Тайлант хугацаанд оролцогч талуудтай хамтран ажиллахдаа дараах асуудлуудад голлон анхаарсан:

- Ил тод байдал, мэдээллийн хүртээмжийг хангах
- Сугалааны үйл ажиллагааны шударга, найдвартай байдлыг баталгаажуулах
- Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах
- Системийн найдвартай ажиллагаа, тасралтгүй байдлыг хангах

- Хууль, зохицуулалтын шаардлагыг мөрдөх

Баримталсан стратеги

Компанийн зүгээс оролцогч талуудтай харилцахдаа дараах стратегийг баримталсан:

- Ил тод, нээлттэй харилцааг эрхэмлэх
- Итгэлцэлд суурилсан урт хугацааны хамтын ажиллагааг хөгжүүлэх
- Дижитал сувгаар мэдээллийг шуурхай хүргэх
- Хараат бус хяналтыг нэвтрүүлж, үйл ажиллагааны шударга байдлыг баталгаажуулах

Хэрэгжүүлсэн арга хэмжээ

Тайлант хугацаанд дээрх стратегийг хэрэгжүүлэх хүрээнд:

- Сугалааны тохирол, үр дүнг олон нийтэд ил тод мэдээлсэн
- Сугалааны тохирлын үйл явцад хөндлөнгийн аудитын оролцоог хангаж, шударга, хараат бус байдлыг баталгаажуулсан
- Холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, хяналт шалгалтыг дэмжсэн
- Хэрэглэгчдэд зориулсан мэдээлэл, зөвлөмжийг цахим сувгаар тогтмол хүргэсэн
- Системийн хэвийн ажиллагааг хангах, сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн

Үр дүн

Дээрх арга хэмжээнүүдийн үр дүнд:

- Сугалааны үйл ажиллагаанд итгэх олон нийтийн итгэл нэмэгдсэн
- Ил тод, хараат бус байдлыг хангах тогтолцоо бэхжсэн
- Үйл ажиллагааны найдвартай, тасралтгүй байдал хангагдсан
- Оролцогч талуудтай хамтын ажиллагаа сайжирсан

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Гранд Системс ХК нь 2025 оны 4 дүгээр улирлын байдлаар 1.6 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй, 1.2 тэрбум төгрөг орлоготой, 45.2 сая төгрөгийн ашигтай байна. Компани нь МХБ-д бүртгүүлж, хувьцаат компани болсон, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн нь ашигтай ажиллахад нөлөөлсөн байна.

Компани нь жилийн санхүүгийн тайландаа Баталгаат Тооцоолол Аудит ХХК-аар аудит хийлгэсэн.

Хараат буё аудиторын тайлан



НЯГТЛАН БОЛОХ БҮРТГЭЛ, ТАТВАР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ БАТАЛГААЖУУЛАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ХОНДЛОНГИЙН БАЙГУУЛАГА “БАТАЛГААТ ТООЦООЛОЛ АУДИТ” ХХК

2026 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр

№26/04/20

Улаанбаатар хот

“ГРАНДСИСТЕМС” ХК-НИЙ ХУВЬЦАА ЭГЭМШИГЧДЭД

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Санаал дүгнэлт

Бид “ГРАНДСИСТЕМС” ХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйцэтгэлийн тайлан болон бусад холбогдох тайлан, мэдээлэл тодруулгуудас бүрэлсэн санхүүгийн тайланг аудит хийж гүйцэтгэлээ.

“ГРАНДСИСТЕМС” ХК -ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон нэгтгэсэн санхүүгийн байдал, орлого үр дүн, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйцэтгэлийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу материаллаг алдаагүй үүн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үнэмсэл

Бид аудитын Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн бэлэн. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчилгээгээ хараат буё байх, эцэс шаардлагуудын дагуу ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан. Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргахад хяналттай бөгөөд зохистой гэж үзэж байна.

Аудитын гол асуулаа

Бидний зорьжигдлын үнэмлэхүй аудитын гол асуудлууд гэж тайлант жилийн санхүүгийн тайланг хянахын ач холбогдолтой, нөлөө бүхий асуудлууд юм. Санхүүгийн тайланг хянах аудитын хүрээнд эцэс шаардлагуудын ач үзсэн ба тусад нь дүгнэлт гаргаггүй.

Санхүүгийн тайлангийн талаар удирдлагын хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт болон Нягтлан болох бүртгэлийн тухай хуулийн дагуу бэлтгэх ба үүн зөв тохируулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Энэхүү үүрэг хариуцлагад нягтлан болох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, нөхцөл байдалдаа тохирсон нягтлан болох бүртгэлийн тооцоолуудыг хийх, санхүүгийн тайлангуудыг алмаа зал мэх эсхүл алдаанаас шалтгаалсан материаллаг буруу илэрхийлэлгүйгээр бэлтгэх, үүн зөвөөр тохируулахтай холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх зэрэг багтана.

Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудитаа үнэмсэл эцэс шаардлагуудын дагуу аудитын нотолгоо өгөх нь бидний үүрэг хариуцлага юм. Бид аудитын Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн. Эцэс шаардлагууд нь санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсх тазар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэх, ёс зүйн шаардлагуудыг мөрдөж ажиллахыг шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана. Аудитын горимуудын сонголт нь санхүүгийн тайлангууд нь алмаа зал мэх, алдаанаас шалтгаалсан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлүүдийн үнэмлэхүй багтаан аудиторын шийдэх хамарна. Тэлгэр эрсдлүүдийн үнэмлэхүй хойсхон аудитор санхүүгийн тайлангуудыг үүн зөв бэлтгэн тохируулахтай холбоотой байгууллагын дотоод хяналтын системийг харгалзан үзэх бөгөөд энэ нь байгууллагын дотоод хяналтын үр дүнтэй байгаа эсэх талаар дүгнэлт өгөх зорилгоор биш, харин нөхцөл байдалдаа тохирсон аудитын горимуудыг тодорхойлоход чиглэнэ. Аудит нь байгууллагын удирдлагын сонгон хэрэглэж байгаа нягтлан болох бүртгэлийн бодлогуудын зохистой эсэх, нягтлан болох бүртгэлийн тооцоолуудын бодитой эсэхийг үнэмлэх аялууд багтана.

Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Монгол Улсын “Компанийн тухай” хуулийн 94 дүгээр туйд заасны дагуу “ГРАНДСИСТЕМС” ХК-ийн хувьцаа эгэмшигчдэд зориулж бэлтгэсэн. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр алмаа нэг зорилгоор хариуцлага хүлээхгүй болно.

ЗАХИРАЛ  М.БУЯНБУЛГАН



Санхүүгийн байдлын тайлан

"ГРАНДСИСТЕМС" ХК-НИЙ 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ			
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН			
Тайлант хугацаа: 2025-12-31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайлан			
№	ҮЗҮҮЛЭЛТ	2024-12-31	2025-12-31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	360,815,982.11	652,408,984.62
1.1.2	Дансны авлага	211,174,464.01	256,980,764.01
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	-	-
1.1.4	Бусад авлага	1,150,300.00	-
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал	13,000,000.00	204,809,400.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	-	-
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	-	-
1.1.10	Богино хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	586,140,746.12	1,114,199,148.63
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	28,469,676.00	47,898,313.28
1.2.2	Биет бус хөрөнгө	371,921,818.18	412,830,909.09
1.2.3	Биологийн хөрөнгө	-	-
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	-	-
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх	-	-
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-
1.2.9	Дуусаагүй барилга	-	-
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	400,391,494.18	460,729,222.37
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	986,532,240.30	1,574,928,371.00
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	675,010,890.00	168,694,333.65
2.1.1.2	Цалингийн өглөг	-	-
2.1.1.3	Татварын өр	22,781,782.68	438,989,485.23
2.1.1.4	НДШ-ийн өглөг	10,899,347.29	4,655,508.53
2.1.1.5	Богино хугацаат зээл	-	-
2.1.1.6	Хүүний өглөг	-	-
2.1.1.7	Нэгдсэн ашгийн өглөг	-	-
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	-	-
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	-	0.47
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй бүлэг хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө) өр төлбөр	-	-
2.1.1.12	Бусад богино хугацаат өр төлбөр	-	-
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	708,692,019.97	612,339,327.89

"БАТАЛГААТ ТООЦООЛОЛ АУДИТ" ХХК

6

"ГРАНДСИСТЕМС" ХК-НИЙ 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ			
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН			
Тайлант хугацаа: 2025-12-31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайлан			
№	ҮЗҮҮЛЭЛТ	2024-12-31	2025-12-31
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	-	-
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	-	-
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	-	-
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	-
2.1.2.5		-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	708,692,019.97	612,339,327.89
2.3	Эздийн өмч	300,000,000.0	375,000,000.0
2.3.1	Өмч: - төрийн	-	-
2.3.2	- хувийн	-	-
2.3.3	- хувьцаат	300,000,000.00	375,000,000.00
2.3.4	Халаасны хувьцаа	-	-
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	-	(35,456,700.00)
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	-	-
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(22,850,000.00)	23,045,743.11
2.3.11	Эздийн өмчийн дүн	277,149,999.99	362,589,043.11
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	986,532,240.30	1,574,928,371.00

"БАТАЛГААТ ТООЦООЛОЛ АУДИТ" ХХК

7

Орлогын тайлан

"ГРАНД СИСТЕМС" ХК-ИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2025-12-31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	2024-12-31	2025-12-31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	140,487,272.73	1,210,396,698.46
2	Борлуулалтын өртөг	-	-
3	Нийт ашиг (алдагдал)	140,487,272.73	1,210,396,698.46
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого	-	-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого	-	-
9	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
10	Ерөнхий ба удирдлагын зардал	294,402,588.09	1,159,290,153.17
11	Санхүүгийн зардал	6,970,000.00	428,567.00
12	Бусад зардал	5,291,900.00	500,000.00
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	-	-
17	Бусад ашиг алдагдал	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(166,177,215.36)	50,177,978.29
19	Орлогын татварын зардал	-	4,972,455.51
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(166,177,215.36)	45,205,522.78
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(166,177,215.36)	45,205,522.78
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн	(166,177,215.36)	45,205,522.78
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

Мөнгөн гүйлгээний тайлан

"ГРАНД СИСТЕМС" ХК-НИЙ 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2025-12-31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайлан

(Төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	12/31/2024	12/31/2025
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	13,361,535.99	1,331,767,032.86
	Бараа борлуулсан, үйлчилгээ	13,361,535.99	1,331,767,032.86
	Эрхийн шимтгэл, хураамж	-	-
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан	-	-
	Буцаан авсан албан татвар	-	-
	Татаас, санхүүжилтийн орлого	-	-
	Бусад мөнгөн орлого	-	-
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	368,958,238.12	1,098,467,073.99
	Ажиллагчдад төлсөн	39,781,771.28	81,098,635.03
	Нийгмийн даатгалын байгууллагад	3,606,400.00	30,666,296.84
	Бараа материал худалдан авахад	-	224,400,000.00
	Ашиглалтын зардалд төлсөн	-	-
	Түлш шатахуун, тээврийн хөлс	-	-
	Хүүний төлбөрт төлсөн	-	-
	Татварын байгууллагад төлсөн	27,787.36	693,120.00
	Даатгалын төлбөрт төлсөн	-	117,612.00
	Бусад мөнгөн зарлага	325,542,279.48	761,491,410.12
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр	(355,596,702.13)	233,299,958.87
2	Хөрөнгө оруулалтын үйл		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
	Хөрөнгө оруулалт борлуулсны	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө	-	-
	Бусад олгосон зээл, мөнгөн	-	-
	Хүлээн авсан хүүний орлого	-	-
	бусад	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	28,469,676.00	76,250,256.36
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд	28,469,676.00	31,250,256.36
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд	-	45,000,000.00
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд	-	-
	Бусад урт хугацаат хөрөнгө олж	-	-
	Бусад олгосон зээл болон	-	-
	Бусад	-	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл	(28,469,676.00)	(76,250,256.36)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	668,249,500.00	170,000,000.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас	-	170,000,000.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт	668,249,500.00	-
	Төрөл бүрийн хандив	-	-
	Бусад	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	35,456,700.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт	-	-
	Санхүүгийн үйл ажиллагааны өглөгт	-	-
	Хувьцаа буцаан худалдаж авахад	-	35,456,700.00
	Бусад	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр	668,249,500.00	134,543,300.00
	Валютын хайндал зөрүү	(0.00)	-
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	284,183,121.87	291,593,002.51
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн	76,632,860.24	360,815,982.11
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн	360,815,982.11	652,408,984.62

"БАТАЛГААТ ТООЦООЛОЛ АУДИТ" ХХК

"ГРАНДСИСТЕМС" ХК-НИН
2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2025-12-31-нээр тасалбар болгосон санхүүгийн тайлан

(төгрөгөөр)

№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2024-12-31-ний үлдэгдэл	300,000,000.00	-	-	-	-	-	(22,159,779.67)	277,840,220.33
2	НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны задруулга	-	-	-	-	-	-	-	-
3	Залруулсан үлдэгдэл	300,000,000.00	-	-	-	-	-	(22,159,779.67)	277,840,220.33
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	-	-	45,205,522.78	45,205,522.78
5	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-	-	-
6	Өмчид гарсан өөрчлөлт	23,000,000.00	(38,456,700.00)	600,000,000.00	-	-	-	-	639,543,300.00
7	Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-	-	-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-	-	-
9	2025-12-31-ний үлдэгдэл	373,000,000.00	(38,456,700.00)	600,000,000.00	-	-	-	23,045,743.11	962,589,043.11